



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 23 өдөр

Дугаар A/43

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай Г


Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоох журам”-ыг шинэчлэн баталсугай.

Хоёр. Энэ журам батлагдсантай холбогдуулан мэргэжил, арга зүйгээр ханганд ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/, тэтгэврийн програмд холбогдох зохицуулалт хийж, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв /Г.Хүрэлбаатар/, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шалгалтын газар /Д.Ганзориг/, сургалт зохион байгуулж, сурталчилгаа явуулахыг Сургалт, олон нийт хамтын ажиллагааны газар /Д.Цэцэгбадам/ -т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэд дарга /Г.Саран/-д даалгасугай.

Дөрөв. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2009 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 136 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.





НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

АЖИЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ
ТӨЛСӨН ТЭТГЭВЭР АВАГЧИЙН ТЭТГЭВРИЙГ
ӨӨРЧЛӨН ТОГТООХ ЖУРАМ

Баримт бичгийн журам: ЖРМ-БХСГ-03-2021

Баталсан: Нийгмийн даатгалын ерөнхий
газрын дарга Д.Зоригт

Хянасан: Бодлогын хэрэгжилт, судалгааны
газрын дарга Ц.Ганцэцэг

Болорвсруулсан: Бодлогын хэрэгжилт, судалгааны,
газрын ахлах мэргэжилтэн С.Лхагвадорж

Бодлогын хэрэгжилт, судалгааны
газрын мэргэжилтэн Ц.Отгонсүрэн

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	




Баримт бичгийн үзүүлэлт

Журмын хариуцагч	Тушаалын дугаар	Батлагдсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
НДЕГ БХСГ	№ 136	2009.04.08	2009.04.08	5

Өөрчлөлтийн тухай тэмдэглэл

Хувилбар	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1	2015.11.23	ISO 9001:2008 олон усын стандартын шаардлагад нийцүүлэн	Да.Нарантуяа
Хувилбар 2	2021.03.23	Ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоох журмыг шинэчлэх	С.Лхагвадорж Ц.Отгонсүрэн
Хувилбар 3			
Хувилбар 4			
Хувилбар 5			



Хувилбар 3



АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоох
6. Тэтгэвэр авагч хүсэлт гаргах, шийдвэрлэх
7. Хяналт



Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2021 оны 3 дугаар сарын **13**ны өдрийн
А43 тоот тушаалын хавсарлт

**АЖИЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЭЛЖ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ
ТӨЛСӨН ТЭТГЭВЭР АВАГЧИЙН ТЭТГЭВРИЙГ
ӨӨРЧЛӨН ТОГТООХ ЖУРАМ**

НЭГ. Зорилго

1.1. Энэхүү журмыг Нийгмийн даатгалын сангаас олгох, тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт тус тус зааснаар тэтгэвэр тогтоолгосны дараа ажил, хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтооход баримтална.

ХОЁР. Хамрах хурээ

2.1. Энэ журамд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 5, 6, 7 дахь хэсгүүдэд заасны дагуу өндөр насын, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тахир дутуугийн, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосны дараа ажил, хөдөлмөр эрхэлж Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар нийгмийн даатгалд албан журмаар даатгуулсан, цэргийн алба хаасан тэтгэвэр авагчид хамаарна.

ГУРАВ. Хамаарах талууд

3.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Хяналт шалгалтын газар, Дотоод аудит, мониторингийн газар, Мэдээллийн технологийн төв, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд.

ДӨРӨВ. Баримт бичгийг хариуцагч

4.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Тамгын газар.



ТАВ. Тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоох

5.1. Энэ журмын 2.1-д заасан тэтгэвэр авагчийн нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д гаргасан хүсэлтийг үндэслэн тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил хөдөлмөр эрхэлж, албан журмаар даатгуулан шимтгэл төлсөн 12 сар тутамд анх тэтгэврийг нь тогтооход баримталсан итгэлцүүрээр өсгөсөн дундаж цалин хөлснөөс 1.5 хувиар, 12 сараас илүү сар тутамд 0.125 хувиар тооцсон дунгээр хүсэлт гаргах үед авч байсан тэтгэврийн хэмжээг нь нэмэгдүүлэн өөрчлөн тогтооно.

5.2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаар өндөр насын болон тахир дутуугийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгосон тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан шимтгэл төлсөн хугацааг энэ журмын 5.1-д заасан тэтгэвэр тогтоолгосноос хойш ажиллан шимтгэл төлсөн хугацаатай нэгтгэн тооцоход мөн хуульд заасан бүрэн тэтгэврийн эрх үүсэхээр бол тэтгэврийг нь бүрэн болгон өөрчлөн тогтооно.

5.3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгосон тэтгэвэр авагчийн анх тэтгэвэр тогтоолгоход баримталсан цэргийн алба хаасан хугацааг энэ журмын 5.1-д заасан тэтгэвэр тогтоолгосноос цэргийн алба хаасан хугацаатай нэгтгэн тооцоход мөн хуульд заасан бүрэн тэтгэврийн эрх үүсэхээр бол тэтгэврийг нь бүрэн болгон өөрчлөн тогтооно.

5.3.1. Цэргийн алба хаасны тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг цэргийн алба хаасан хугацаанд шилжүүлэн тооцо замаар тэтгэврийг нь өөрчлөн тогтоохгүй. Зөвхөн энэ журмын 5.1-д заасны дагуу нэмэгдлийг тооцож олгоно.

5.4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсөн өвчний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил, хөдөлмөр эрхэлж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол энэ журмын 5.1-д зааснаар тэтгэврийн хэмжээг нь нэмэгдүүлэн өөрчлөн тогтооно.

5.5. Тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил, хөдөлмөр эрхлэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэтгэвэр авагчийн хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон бол шимтгэл төлсөн хугацаа (1 жил 1.5 хувь, жил хүрээгүй тохиолдолд сар 0.125 хувь)-гаар тэтгэврийг нь нэг удаа өөрчлөн тогтооно. Харин хөдөлмөрийн харилцаа үргэлжилж байгаа бол ажлаас чөлөөлөгдсөн шийдвэр гарсан эсэхээс үл хамааран 12 сар тутамд тэтгэврийг нь өөрчлөн тогтооно.

5.6. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 6, 7 дахь хэсэг, мөн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан 20/23/25-аас доошгүй жил алба хаасан гэсэн нөхцөлөөр бүрэн тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч

Хувилбар 3





байгаа, энэ журмын 2.1-д заасан тэтгэвэр авагчийн тэтгэврийг тэтгэврээ өөрчлөн тогтоолгох үед авч байсан бүрэн тэтгэврийн доод хэмжээн дээр анх тэтгэврийг нь тогтооход баримталсан итгэлцүүрээр өсгөсөн дундаж цалин хөлснөөс энэ журмын 5.1-д заасан хэмжээгээр тооцсон дүнгээр нэмэгдүүлэн өөрчлөн тогтооно.

5.6.1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэврийг бүрэн тэтгэврийн доод хэмжээгээр авч байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийг энэ журмын 5.6-д заасны дагуу өөрчлөн тогтооно.

5.7. Тэтгэвэр авагчийн энэ журмын 5.2, 5.3-т зааснаар нэгтгэн тооцсон хугацаа нь бүрэн тэтгэвэр тогтоох хугацаанд хүрэхгүй, эсхүл энэ журмын 5.6-д зааснаас бусад нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосны улмаас тэтгэврийн хэмжээ нь нэмэгдэхгүй тохиолдолд тэтгэврийг хэвээр нь олгоно. Энэ тохиолдолд шимтгэл төлсөн нийт хугацааг шинэчлэн тооцон мэдээллийн санд оруулж, тэтгэвэр тогтоолтын хуудсыг 2 хувь хэвлэн, нэг хувийг нь тэтгэврийн хувийн хэрэгт хавсаргаж, нөгөө хувийг нь тэтгэвэр авагчид өөрт нь өгнө.

5.8. Энэ журмын 2.1-д заасан тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил, хөдөлмөр эрхэлж шимтгэл төлсөн хугацаа нь энэ журмын 5.1-д заасан хугацаа (12 сар)-нд хүрээгүй тохиолдолд тэтгэврийн хэмжээг өөрчлөхгүй.

5.9. Цалин хөлсний тодорхойлолт, холбогдох баримт олдоогүйгээс дундаж цалингүйгээр тэтгэвэр тогтоолгосон энэ журмын 2.1-д заасан тэтгэвэр авагч, мөн тэтгэвэр тогтоолгосноос хойш нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тахир дутуугийн тэтгэвэр авагчийн тэтгэврийг энэ журмын дагуу өөрчлөн тогтоохгүй.

ЗУРГАА. Тэтгэвэр авагч хүсэлт гаргах, шийдвэрлэх

6.1. Энэ журмын 2.1-д заасан тэтгэвэр авагч тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д цахимаар эсхүл цаасан хэлбэрээр гаргана.

6.2. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь тэтгэвэр авагчийн энэ журмын 6.1-д заасан хүсэлтийг <http://daatguulach.ndaatgal.mn> болон гар утасны “нийгмийн даатгал” аппликацийн, мессэжээр, эсхүл цаасан хэлбэрээр хүлээн авч доор дурдсанаар тэтгэврийг өөрчлөн тогтооно:

6.2.1. програмын дагуу гаргасан жагсаалтыг үндэслэн хүсэлт гаргасан тэтгэвэр авагчийг тэтгэвэр тогтоолгосноос хойш сар бүр тухайн үед мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ эсхүл түүнээс дээш хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос шимтгэл төлсөн эсэхийг шалгана;

6.2.2. хүсэлт гаргасан тэтгэвэр авагч сарын дундуур ажилд орсон, чөлөөлөгдсөн, тухайн үед мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс





доогуур цалин хөлснөөс шимтгэл төлсөн зэрэг үндэслэлийг шалгах шаардлагатай тохиолдолд холбогдох тушаал, шийдвэр, цалин хөлсний баримт бичгийг үндэслэнэ;

6.2.3.энэ журмын 6.2.1, 6.2.2-т заасны дагуу хянан хүсэлт гаргасан тэтгэвэр авагчийн тэтгэврийг энэ журамд зааснаар өөрчлөн тогтоож, тогтоолтын хуудсыг програмаас хоёр хувь хэвлэн холбогдох хяналтын байцаагч болон тасгийн даргаар хянуулан баталгаажуулна;

6.2.4.тэтгэврийн байцаагч өөрчлөн тогтоосон тэтгэврийг баталгаажуулсаны дараа банкинд илгээх тэтгэврийн файлыг бэлтгэнэ.

6.3. Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч) нь тэтгэвэр авагчийн өөрчлөгдсөн тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 28 дугаар зйулийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан олгоно.

ДОЛОО. Хяналт

7.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтан, ажилтан, хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ

